



**ЗАВХАН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/52

Улиастай

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Улсын нөөцийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 63 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 63 дугаар тогтоолоор Онцгой байдлын газрын 173 дугаар салбар, цэгүүдээс цагаан зудтай өвөлжилт хүндэрсэн сумдад малын тэжээлийг хуваарилалт хийж, үнэгүй олгох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн  
дарга:

Д.Азжаргал

Хөгжлийн бодлого, төлөвлөлт,  
хөрөнгө оруулалтын хэлтсийн  
дарга

Ө.Болд

Онцгой байдлын газрын  
дарга, хурандаа

Н.Отгонжаргал

Цагдаагийн газрын дарга,  
дэд хурандаа

Э.Балжинням

Хүнс, хөдөө аж ахуйн газрын  
дарга

Нарийн бичгийн  
дарга:

С.Батбаяр

Онцгой байдлын газрын 173  
дугаар салбарын дарга

2. Сумдын өвөлжилтийн цаг үеийн нөхцөл байдал, малчин өрх, малын тоо толгойн талаарх мэдээллээр ханган ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Э.Балжинням)-т үүрэг болгосугай.

3. Хямдралтай үнээр олгох тэжээлийг холбогдох мэдээллийн дагуу хуваарь гарган батлуулахыг ажлын хэсэг (Д.Азжаргал)-т даалгасугай.

ДАРГА



Г.ӨНӨРБАЯР

Захирамж-2024

8109010208